



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/119

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.18 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 29 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан хаагчдын томилолтын зардалд 3,400,000 (гурван сая дөрвөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай

3. Зардалд шаардагдах 3,400,000 (гурван сая дөрвөн зуун мянга) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН



Сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар  
сарын 30-ны өдрийн А/119 дүгээр  
захирамжийн хавсралт



### АЛБАН ХААГЧДЫН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Албан хаагчдын албан томилолт	Нэг хүний томилолтын зардал	Хоног	Нийт томилолтын зардал
	1	2	3	4
1	Б.Янжиндулам	170,000	5	850,000
2	Б.Энхмаа	170,000	5	850,000
3	Ш.Бумандолгор	170,000	5	850,000
4	А.Мягмардавга	170,000	5	850,000
	Нийт дүн	680,000	20	3,400,000

---oOo---